



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 12 сарын 10 өдөр

Дугаар А/568

Улаанбаатар хот

Сонгинохайрхан дүүргийн 113 дугаар
цэцэрлэгийн эргэлтийн бус хөрөнгийг
данснаас хасах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/481 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 12 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сонгинохайрхан дүүргийн 113 дугаар цэцэрлэгийн эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй 3 нэр төрлийн нийт 3,408,500.00 (гурван сая дөрвөн зуун найман мянга таван зуу) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Сонгинохайрхан дүүргийн 113 дугаар цэцэрлэг (Н.Нарангэрэл)-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй 2 нэр төрлийн 686,000.00 (зургаан зуун наян зургаан мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг устгалын акт үйлдэн устгах, татан төвлөрүүлэхээр шийдвэрлэсэн 1 нэр төрлийн 2,722,500.00 (хоёр сая долоон зуун хорин хоёр мянга таван зуу) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Нийслэлийн Өмчийн харилцааны газарт актаар хүлээлгэн өгөхийг Сонгинохайрхан дүүргийн 113 дугаар цэцэрлэг (Н.Нарангэрэл)-т, татан төвлөрүүлэх ажлыг зохион байгуулж, ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Т.Оюунтуул)-т тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, шалгалтын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



В.ОЮУМАА

115050186

